



## ХОЁР. ИННОВАЦ, БИЗНЕС ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЗОРИЛГО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ҮҮРЭГ

### 1. Газрын нэр: Инновац, бизнес хөгжлийн газар

#### 1.1. Зорилго:

Компанийн бизнесийн тогтвортой хөгжлийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор дунд, урт хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулах, тэдгээрийг үр дүнтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн төлөвлөлт, бодлого арга зүйн удирдамжаар чиглүүлэх, компанийн ашигт ажиллагааг дээшлүүлэхэд бизнес төлөвлөлт хийж, гүйцэтгэлийг хангуулах, зах зээлийн эрэлт хэрэгцээ, нөөцийн судалгаанд үндэслэн бизнес хөгжүүлэлтийг үе шаттай хийж, хэрэгжүүлэх, бүтээгдэхүүнийг тодорхойлох, хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ тарифыг үндэслэлтэй тогтоох, хууль эрх зүй, зохицуулалт болон өрсөлдөөний орчинд компани үр нөлөө, үр ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

#### 1.2. Зохион байгуулалтын бүтэц:



**1.3. Үйл ажиллагааны чиг үүрэг:** Зорилгыг биелүүлэх ажлын хүрээнд дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн дунд, урт хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах;
- Стратегийн төлөвлөгөөний хүрээнд жил бүрийн бизнес төлөвлөгөө хийх, батлуулах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах;
- Компанийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үйл ажиллагааны тайланг нэгтгэх, хэрэгжилтийг хянах;
- Зах зээлийн судалгаа шинжилгээ хийх, орлогын өсөлтийг дэмжих бизнес хөгжүүлэлтийн төсөл хөтөлбөр боловсруулах, үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах, тайлагнах;
- Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг үр дүнтэй хийж, шинэ үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах;

- Компанийн өрсөлдөх чадварыг тогтвортой сайжруулахад чиглэсэн маркетингийн оновчтой бодлого стратегийг тодорхойлох;
- Борлуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, үнэлэх;
- Техник технологийн хөгжил, өргөтгөл шинэчлэлийн судалгаа хийж, төлөвлөлт гаргах, батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг хангуулах, тайлагнах;
- Хууль эрх зүй, зохицуулалтын орчинд компанийн бодлогыг тусгах, уялдуулах;
- Бизнесийн хөгжлийн чиглэлийг тодорхойлж, дунд хугацаанд төлөвлөн, хэрэгжилтийг үе шаттай хангах;
- Зах зээлийн эрэлт хэрэгцээ, өсөлт бууралт, технологийн өөрчлөлтийн судалгааг тогтмол хийж, богино, дунд, урт хугацааны өөрчлөлтийг таамаглах, бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг хийж, борлуулалтыг дэмжих;
- Төслийн менежментийг нэвтрүүлэх, төслийн удирдлагын бичиг баримтыг боловсруулан ашиглах;
- Хөрөнгө оруулалтыг төслийн судалгаа, тооцоолол, төлөвлөлт, хэрэгжүүлэлт, явцын хяналт, хаалтын бүрэн циклээр төлөвлөн, хэрэгжилтэд хяналт тавих;
- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс зарласан тендер, худалдан авалтын мэдээллийг тогтмол судалж, оролцох шаардлагатай тендерийн жагсаалтыг гарган цаг тухайд нь удирдлагад танилцуулах;
- Тендер, уралдаант шалгаруулалтын техникийн хэсгийн төсөл, баримт бичгийг боловсруулах, хянах;
- Бизнес төлөвлөгөөнд тусгах, техник технологийн шийдлийг боловсруулж, хэрэгжүүлэх боломжтой, төслийн техникийн тооцоог хийх;
- Бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан техник технологийн төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, хүлээн авах.

## **2. Албаны нэр: Бодлого төлөвлөлтийн алба**

### **2.1. Зорилго:**

- *Компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөөг боловсруулах, ашигт ажиллагааг хангах үйл ажиллагааны чиглэлийг оновчтой сонгох, дунд, урт хугацааны стратеги төлөвлөгөөтэй уялдуулах, үнэ тарифыг эдийн засгийн өгөөжтэйгөөр тогтоох, компанийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэн дүгнэх, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, аймаг, дүүрэг, бүсийн холбооны газруудын санхүү, хэрэглэгчийн тооны зорилтот түвшнийг тогтоох, хэрэгжилтэд улирлаар үнэлгээ өгөх;*
- *Зах зээлийн эрэлт хэрэгцээ, нөөц боломжийн судалгаанд үндэслэн бизнес хөгжүүлэлтийг үе шаттай хийж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг тогтмол хийж, борлуулалтыг дэмжин ажиллах;*
- *Компанийн технологийн өрсөлдөх чадварыг сайжруулж, техник технологийн шинэчлэл хийх дунд, урт хугацааны төлөвлөлт хийж, хэрэгжилтийг үе шаттайгаар хангах, хөрөнгө оруулалтыг үр өгөөжийн тооцоололд үндэслэн сүлжээ, дэд бүтцийн найдвартай ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний сонголт, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглүүлэх, төслийн менежментийг үр нөлөөтэй хэрэгжүүлж ажиллах.*

## 2.2. Зохион байгуулалтын бүтэц:



## 2.3. Үйл ажиллагааны чиг үүрэг: Дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн дунд, урт хугацааны хөгжлийн чиглэл, стратегийг тодорхойлоход шаардлагатай бүх төрлийн шинжилгээ, судалгааг хийж, дүгнэлт гаргах;
- Дунд, урт хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах;
- Жил бүрийн бизнес төлөвлөгөөг нэгтгэх, хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийг хянах, биелэлтийг нэгтгэн тайлагнах;
- Газар, нэгжүүдийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн, компанийн үйл ажиллагааны жилийн нэгдсэн төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг үнэлэх;
- Компанийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн, холбогдох газарт хүргүүлэх;
- Компанийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, жил бүрийн зорилтот түвшнийг төлөвлөн, биелэлтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэн удирдлагад тогтмол тайлагнах;
- Компанийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ тарифыг журмын дагуу тогтоож батлуулах, мөрдөлтөд хяналт тавихад оролцох;
- Компанийн засаглал, менежментийн тогтолцоог сайжруулах санал гаргах, арга зүйгээр хангаж ажиллах;
- Компанийн зорилтот түвшний үзүүлэлтүүдийг үнэлэн дүгнэх, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах;
- Аймаг, дүүрэг, бүсийн холбооны газруудын санхүү, хэрэглэгчийн тооны зорилтот түвшнийг хуваарилан тогтоох, хэрэгжилтэд хяналт тавьж, улирлаар үнэлгээ өгөх;
- Салбарын бодлого, зохицуулалт, шударга өрсөлдөөний орчинд компанийн үйл ажиллагааг уялдуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах;
- Салбарын холбогдолтой хууль, дүрэм журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, норм нормативын бичиг баримтад компанийн саналыг тусгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх.